



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠙᠑᠑ оны ᠐ᠪ сарын ᠐᠖ өдөр

Дугаар А/᠒᠘7

Мандалговь

Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх
“Эцэг эхийн зөвлөл”-ийн зөвлөгөөн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 6᠐ дугаар зүйлийн 6᠐.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Сангийн сайдын 2021 оны ᠐4 дүгээр сарын 2᠐ -ны өдрийн 61 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэхь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны ᠐4 дүгээр сарын ᠐6-ны өдрийн ᠐6 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд байгууллага, хуулийн этгээд нь өөрийн ажил үйлчилгээ болон ажилтан албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг, харилцаагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх үүрэг чиглэл бүхий эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн зөвлөгөөнийг зохион байгуулсугай.

2.Зөвлөгөөний үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Зөвлөгөөний үйл ажиллагаанд зарцуулагдах нийт 860,000 (Найман зуун жаран мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100355